ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 18 өдөр Дугаар А/191 Мандалговь

"Тааны амт" ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/133 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сан, "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Хүнсний ногооны зоорь шинээр барих" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Тааны амт" ХХК-тай 119,853,542 (нэг зуун арван есөн сая найман зуун тавин гурван мянга таван зуун дөчин хоёр) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу Хүнсний ногооны зоорь шинээр барих ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Тааны амт" ХХК-ний захирал (Ю.Отгондэлгэр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХТАЙВАН

486215

Боловсруулсан:
Хянасан:
Хувь: 2